



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдөр

Хурал болсон газар: Монголын Мянганы сорилтын сан, “Туул” хурлын танхим

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-гийн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлаар дор дурьдсан 8 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-гийн Удирдах Зөвлөлийн зарим гишүүд Компакт гэрээ хүчин төгөлдөр болоход шаардагдах урьдчилсан болзолт нөхцөлүүдийг хангах чиглэлээр хийгдэж байгаа ажлын явцын талаар мэдээлэл хийв.
2. Монголын МСС-гийн Удирдах Зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн хурлын тэмдэглэлтэй гишүүд танилцаад санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-гийн 2020.07.01-нээс 2021.06.30-ны хооронд хэрэгжүүлэх Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцээд санал нэгтгэйгээр батлав.
4. Монголын МСС-гийн 2020 оны гуравдугаар улирлын санхүүжилтийн төлөвлөгөөний төслийг хэлэлцсэний үндсэн дээр Удирдах Зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
5. Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн менежментийн бодлогын баримт бичгийн төслийг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцээд санал нэгтгэйгээр батлав.
6. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой хэрэгжиж буй хорио цээр, хязгаарлалтын улмаас зарим гэрээнд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг хэлэлцсэний үндсэн дээр Удирдах Зөвлөлийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
7. Худалдан авах ажиллагааны төлөөлөгчтэй байгуулсан гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Удирдах Зөвлөлийн гишүүд хэлэлцээд санал нэгтгэйгээр батлав.
8. Худалдан авах болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын дүн, Ёс зүйн дүрэм, Авлига болон санхүүгийн луйврын эсрэг төлөвлөгөөг тус тус танилцуулав.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН